

## Үндэсний ухамсар

**М.Мөнхзул** докторант

**Түлхүүр үг:** Үндэсний ухамсар, ердийн үндэсний ухамсар, онолын үндэсний ухамсар, интернационализм, үндэстэн, угсаатан, үнэлэмж

**Товч хураангуй:** Үндэсний ухамсар нь ердийн ахуйн байдлаар илэрдэггүй боловч улс төрийн хүрээнд ялангуяа сонгуулийн үед энэхүү удирдамж нь илэрч гардаг. Энэ илэрхийлэл нь улс төрийн хүрээнд тухайн үндэстэн угсаатны бүлгийн төлөөлөгчтэй шууд бодит харьцаанд ороогүйтэй холбоотой юм. Ердийн үндэсний ухамсрын тодорхой тогтвортой байдлыг хангаж өгдөг хэсгүүдэд зан заншил ордог. Тухайн үндэсний заншил нь тогтвортой өвөрмөц байдлаараа шинэ үеийн зан байдлыг зохицуулах ба тогтворжуулах үүргийг гүйцэтгэдэг.

**Судалгааны материал, арга зүй:** Уг өгүүллийг бичихдээ өрнө дахины тэр дундаа ОХУ-ын судлаачдын ном зохиол, илтгэлийг түлхүү ашигласан болно. Энэхүү судалгааны ажилд нийгмийн шинжлэх ухааны ерөнхий арга болох харьцуулалтын арга, хийсвэрлэх арга, түүхэн ба логик аргыг ашиглахаас гадна олон ургальч үзлийн зарчим болон асуудалд бодитой хандах зарчмыг баримталсан билээ.

**Судалгааны үр дүн:** Үндэсний ухамсар гэдэг нь үндэс угсаатны бүлгийн оюунлаг хөгжлийн түвшин ба онцлог агуулгыг тодорхойлж буй нийгмийн, улс төрийн, эдийн засгийн, ёс суртахууны, гоо зүйн, философийн, шашны болон бусад үзэл баримтлалын нийлбэрийг хэлж байгаа юм. Үндэсний төлөв байдалтай харьцуулбал арай илүү рациональ шинжтэй боловч уг рациональ шинж нь зөвхөн онолын хэлбэрт илэрхийлэгддэг. Үндэсний ухамсар нь үндэсний сэтгэлзүйн хэв маягийн “дээд давхар” нь юм<sup>31</sup>. Тэр нь өөртөө нийгмийн янз бүрийн үнэлэмжид бүлгийн харьцааг багтаадаг. Түүний түүхэн хөгжил өнгөрсөн үеийн ололт ба ирээдүйн өмнө тавигдаж байгаа зорилтын үйл явцыг тусгадаг. Үндэсний ухамсрын цөм нь үндэсний өөрийн ухамсар болдог. Үндэсний ухамсрын элементүүдэд дараах зүйлсүүд орно. Үүнд:

1. Оюунлаг ба материаллаг үнэлэмжид үндэсний ухамсар шингэсэн харьцаа
2. Бүтээмж нэмэгдүүлэх зорилгоор бүтээлчээр хандах чадвар
3. Үндэсний эрх ашиг ба бусад үндэстэн угсаатны бүлгүүдтэй ашигтай харилцааг бий болгохын тулд өөр хоорондоо нэгдэх шаардлагатай гэдгийг ухамсарлах явдал юм<sup>32</sup>

Үндэсний ухамсар нь аливаа нийгэм, улс төрийн ухамсрын хэлбэрийн хувьд нэлээд нарийн диалектик харилцан холбоотой бөгөөд харилцан нөхцөлдсөн хоёр чухал бүрэлдэхүүн хэсгийн нэгдлийг илэрхийлдэг. Үүнд: ердийн ба онолын ухамсар орно.

### Ердийн үндэсний ухамсар

Ердийн үндэсний ухамсар нь үндэсний төлөв байдалтай нарийн холбоотой байдаг ба үндэстэн угсаатны өдөр тутмын сэтгэлзүйг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл,

<sup>31</sup> Поздняков Э.А.Нация. Национализм.Национальные интересы.М.,1994 х45

<sup>32</sup> Поздняков Э.А.Нация. Национализм.Национальные интересы.М.,1994, х46-47

үндэсний ухамсрын эмпирик түвшин нь болдог байна. Харин онолын үндэсний ухамсар нь нэлээд өндөр түвшний ухамсрыг хэлнэ. Тэрээр бүлгийн ердийн төсөөлөл, хэрэгцээ, хүсэл зориг, эрмэлзлэлийн сонголтын үр дүн нь болдог. Үндэсний ухамсрын рациональ үзэл суртлын түвшинг илэрхийлдэг гол хүчин зүйл нь үндэсний үзэл суртал юм. Ердийн үндэсний ухамсар нь өөрийн бүтэц ба механизмаар хэлбэрээ өөрчилж байдаг нэлээн нарийн давхаргатай зөрчилтэй байгууламж юм. Түүнээс гадна ердийн үндэсний ухамсар нь үндэсний төлөв байдалтай маш нарийн уялдаа холбоотой ба байгаль нийгмийн туршлагын үе үеийн түүхийн задлан шинжилгээний өвөрмөц хэлбэр бөгөөд үндэстний ихэнх төлөөлөгчдийн тодорхой нийгэм, улс төрийн оршихуйг илэрхийлэхээс гадна түүхэн хөгжлийн бүтээгдэхүүн нь болдог онцлогтой. Ердийн үндэсний ухамсрын бүтцийг 3 үед хуваадаг.

1. Ердийн ухамсрын дотоод бүтцэд өдөр тутмын хэрэгцээ сонирхол, үнэлэмжийн тогтолцоо ба баримжаалал ордог бөгөөд энэ нь тухайн нэгтгэлийн хөгжлийн тодорхой үе шатыг тусгадаг.
2. Ердийн үндэсний ухамсрын чухал элементэд тодорхой үнэлэмжийн тогтолцооны үндсэн дээр бий болсон стереотип араншин, үндэстний зан заншил орно.
3. Ердийн үндэсний ухамсрын нэлээд чухал хэсгүүд нь сэтгэл хөдлөлийн элемент болсон тэдний удирдамжийн дагуу өдөр тутмын амьдралын өвөрмөц байдлыг бүрдүүлж буй дуу авиа, өнгөөр илэрхийлэгддэг хэлбэрүүд ордог бөгөөд үндэсний зан араншинтай холбогдож үндэсний ухамсраар илэрхийлэгддэг.

Ердийн "анхдагч" үндэсний ухамсар нь хүмүүсийг өөрийгөө тодорхой үндэсний ба угсаатны бүлэгт хамааруулж буйг ухамсарлах хэлбэрээр илэрхийлэгддэг. Үндэстэн угсаатны мэдрэмж, үзэл бодол, зан байдлын хэм хэмжээ ба загварууд нь үнэлэмжийг ердийн түвшинд мөрдөж байгааг тусгадаг. Энэхүү мэдрэмж үзэл бодлууд нь нийтлэг газар нутаг, хэл, соёл, ард түмний зан заншлаас үүсэж гарсан. Энэхүү хүчин зүйлүүд нь тогтвортой байдлыг харуулж байгаа боловч түүнд хүний сэтгэцийн уян хатан байдал ба тойрон хүрээлж буй бодит байдалтай харьцах харьцаатай холбоотой тодорхой динамик шинж агуулагддаг. Ердийн үндэсний ухамсрын динамик элементүүдийн тоонд хэрэгцээ ордог. Нийгэм, улс төрийн харилцааны тогтолцоонд аливаа өөрчлөлт гарснаар тэр нь хэрэгцээний системд өөрчлөлт оруулж, өөрчлөгдсөн нөхцөл байдлын дагуу шинэ хэрэгцээ бий болгож хуучин хэрэгцээг шинэчилдэг. Мөн түүний хэрэгжилтийн аргуудын хэлбэрүүдийг өөрчилснөөр түүний шинжүүдийг ч мөн өөрчилдөг. Шинэ буюу өөрчлөгдсөн хэрэгцээнүүд нь ердийн үндэсний ухамсрын өөр болон арай бага хөдөлгөөнт хэрэгцээнүүдтэй зөрчилд ордог. Жишээ нь: хуучин стереотип төсөөлөл ба зан заншил. Үүний улмаас дотоод зөрчил ба сэтгэцийн мөргөлдөөн бий болж сэтгэл хөдлөл мэдрэмжийн хүрээний өөрчлөлтөөр илэрхийлэгддэг. Энэ нь хүмүүсийн зан байдлын диалектикт маш тод илэрхийлэгддэг. Хэрэгцээний ханамжийн түвшинг илэрхийлж байгаагийн хувьд зан байдал нь ердийн үндэсний ухамсрын хамгийн хөдөлгөөнтэй бүрэлдүүлэх хэсэг нь болдог. Энэ динамизм нь зан байдлыг бүрэн хэмжээгээр ухамсарлаагүйгээс болж нэмэгддэг бөгөөд тэднийг ухамсартайгаар хянах боломжийг сулруулдаг. (Жишээ нь: 7-р сарын 1-ны үйл явц.) Зан байдлын улс төрийн илэрхийллийн агуулга ба хэлбэрийг зарим тохиолдолд энэхүү хяналтанд оруулж болдог. Сэтгэл хөдлөл ба зан байдлын хүрээ нь ердийн үндэсний ухамсрын илэрхийлэлд нэлээд байр суурийг эзэлдэг бөгөөд үндэсний ухамсрын бүх цогцолборт маш хүчтэй нөлөө үзүүлдэг. Ердийн үндэсний ухамсрын тогтвортой ба идэвхгүй байдлыг хангаж байдаг сэтгэл хөдлөлийн баримжаа нь

үндэстэн угсаатны стереотип ордог. Тухайлбал, үе үеийн ард түмний өөр үндэстэнд хандах хандлагыг илэрхийлсэн байдаг. Гэхдээ энэхүү аливаа төсөөлөл нь нууц байдалд хадгалагддаг. Өөрөөр хэлбэл, **үндэсний ухамсар нь хүний дотоодод байдаг ч байнга илэрхийлэгддэггүй гэсэн үг**<sup>33</sup>.

Үндэсний ухамсар нь ердийн ахуйн байдлаар илэрдэггүй боловч улс төрийн хүрээнд ялангуяа сонгуулийн үед энэхүү удирдамж нь илэрч гардаг. Энэ илэрхийлэл нь улс төрийн хүрээнд тухайн үндэстэн угсаатны бүлгийн төлөөлөгчтэй шууд бодит харьцаанд ороогүйтэй холбоотой юм. Ердийн үндэсний ухамсрын тодорхой тогтвортой байдлыг хангаж өгдөг хэсгүүдэд зан заншил ордог. Өөрөөр хэлбэл, нэг үеэс нөгөө үерүү дамжигддаг хүний зан байдалд тавигддаг хэм хэмжээний шаардлагагууд ордог бөгөөд тэр нь өнгөрсөн үеийн үнэлэмжийн тогтолцооны гүнд оршиж байгаа баримжаалал, үндэстэн угсаатны бүлгийн нийгэм, улс төрийн ой санамжид тулгуурладаг. Үндэсний заншил нь тогтвортой өвөрмөц байдлаараа шинэ үеийн зан байдлыг зохицуулах ба тогтворжуулах үүргийг гүйцэтгэдэг. *(Нас барсан хүмүүсийн заншил нь амьд хүмүүст үргэлж гай дарамт болдог ба цаашлаад нийгэм-улс төрийн шинэлэг байдалд төвөг учруулдаг)*<sup>34</sup>.

Зан үйл ба ёс заншил нь олон жилийн турш туршиж хэрэглэсэн тухайн нэгтгэлийн амьдрахуйн “байгаль-түүхийн” нөхцөл байдлын үүсэл ба тусгалтай холбоотой гэж үздэг байсан байна. Нөгөө талаас олон жилийн турш олж авсан өнгө төрхөөрөө тодорхой түүхэн үетэй холбоотой байдаг бөгөөд тэр үед нь ноёлж байсан улс төрийн хүчний баримталж байсан үнэлэмжийн тогтолцоог илэрхийлдэг байсан тул уг үнэлэмжийг дагаж мөрддөг хүмүүсийн хувьд тэр нь “гэгээлэг” гэж тооцогддог байв. Зан үйл ба ёс заншил нь бага ястан болон бусад харьцангуй жижиг үндэстэн угсаатны байгууламжийн хувьд маш их чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрийн зан үйл ба ёс заншлыг хадгалах үйл явц нь өөрийгөө хамгаалах шаардлага болдог бөгөөд сэтгэл зүйн гадаад нөөц дутагдах үед өөрийн дотоод нөөцийг нэмж дайчилснаар нэг үндэстний соёлд хамаарч амьд үлдэх нөхцөл болдог байсан. Өөрийн үндэсний зан үйл ба заншилд хэт их анхаарал төвлөрүүлэх асуудал нь том гүрэн үндэстний зүгээс бага үндэстэн ястанд нөлөөлөх бодлогын хариу болгож өөрийн үндэстнийг баталгаажуулах хэлбэр болдог. Энэ тохиолдолд зан үйл ба ёс заншил нь ердийн үндэсний ухамсрын хэсгүүдийн хувьд үндэсний улс төрийн туршилтыг дамжуулах хэрэгсэл болдог. Мөн үндэсний нэгтгэлийн нэгдэх үндэсний ухамсрыг сэргээх багаж болдог. Ердийн үндэсний ухамсрын тархалт нь маш энгийн байдлаар явагддаг. Энэ нь түүний нотолгооны нөлөөтэй холбоотой. Үндэсний ухамсрын тархалт нь хэд хэдэн сэтгэлзүйн механизмын үйлдэл дээр тулгуурладаг. Үүнд: бүлгийн дарамт ба конформизмын (бие хүн бүлгийн нөлөөнд автагдах) үзэгдэл, өөрийн хувийн асуудлаа нэгтгэлийн асуудал руу шилжүүлэх. Мөн өөрийгөө бүлэг хүмүүстэй ижилсүүлэх хэрэгцээ, олонхи хүмүүсийн (масс) итгэл үнэмшил гэх мэт сэтгэлзүйн механизмын үйлдлүүд явагддаг. Үндэсний ухамсрын тархалтын механизм нь хоорондоо холбоотой боловч нөгөөтэйгүүр эсрэг тэсрэг зорилтыг гүйцэтгэдэг. Нэг талаас нэг үндэстэн угсаатны төлөөлөгчдийг нэгтгэн ойртуулах зорилтыг гүйцэтгэдэг бол нөгөө талаас өөр нэгтгэлүүдийн гишүүдийг бие биенээс нь тусгаарлах буюу эсрэгцэн үзэх зорилтыг гүйцэтгэдэг. Энэ утгаараа ердийн үндэсний ухамсар нь өдөр тутмын түвшин дэх үндэстэн угсаатны мөргөлдөөний гол сэтгэлзүйн үндэс нь болдог. Уг ердийн үндэсний ухамсарт үндэсний зан байдалтай холбоотой үндэсний үзэн ядалт, тэдний хуучинсаг үзэл, сөрөг агуулгатай

<sup>33</sup> Поздняков Э.А.Нация. Национализм.Национальные интересы.М.,1994

<sup>34</sup> Мөн тэнд

стереотипүүд, үндэсний ба арьс өнгөний бие биенээ тэвчихгүй байдал газар авдаг. Энэ үзэгдлүүд нь хамгийн энгийн түвшинд эхэлж яваандаа зөвхөн орон нутгийн хэмжээгээр зогсохгүй нэлээд нарийн улс төрийн нэг хэсэг нь болдог.

### Онолын үндэсний ухамсар

Онолын үндэсний ухамсар нь тодорхой нийгэм, улс төрийн байр сууринаас хэрэгждэг, шинжлэх ухааны хувьд бүрэлдэн тогтсон ба нийгэм-улс төрийн хувьд тодорхой чиг баримжаатай олон түмний ердийн үндэсний ухамсрын сонгож авсан элементүүдийн нийлмэл юм. Энэ нь үндэстэн угсаатны бүлгийн үзэл бодол болдог бөгөөд дотроо өнгөрсөн түүх, өнөөдрийн байдал, үндэсний хөгжлийн зорилгын нийлбэр, түүнд хүрэх хөтөлбөрийн эерэг үнэлэмж зэрэг багтана<sup>35</sup>. Мөн бие хүн бүр заавал дагаж мөрдөх хэм хэмжээ үнэлэмж ба зан байдлын загварыг багтаадаг. Ийм үзэл бодлын байгууламжийн төвд өөрийн үндэстэн угсаатны бүлэг нь сонгомол давуу гэсэн санаа нь орших боломжтой болж энэ байгууламж нь цаашид этно төвийн шинжтэй болох буюу үндсэрхэг, арьс өнгөний үзэл нэлээд дээд хэмжээнд хүрэх магадлалтай. Гэвч энэхүү хувилбарт онолын үндэсний ухамсрын олон тооны боломжийг нийцүүлэх шаардлага байхгүй.

Онолын үндэсний ухамсрын хамгийн хялбар тодорхойлолт нь үндсэндээ догматик шинжүүдийг агуулсан тоталитар төрийн бүрэлдэн тогтох, цэцэглэх үетэй холбоотой байдаг. (Үүний нэг илрэл нь Оросын националь шованизм) Өөрийн үндэсний үзэлд тавих анхаарал дээр тулгуурласан онолын үндэсний ухамсар нь өнөө үеийн зөрчилтэй боловч харилцан холбоотой ертөнцөд үндэстэн ард түмний харилцан хамаарлыг бодитоор ойлгох үүднээс хандаж болно. (Үүнийг интернационализмтай холбож ойлгож болно. Өөрөөр хэлбэл, локализацийн асуудал хөндөгдөж байна) Энэхүү үзэл суртлын байгууламж нь зарчмын хувьд өөр агуулгатай болж интернациональч шинжийг илэрхийлдэг.

Онолын үндэсний ухамсрын хувилбарыг ангилж төрөлжүүлэх боломжийг олгодог түлхүү асуудал нь янз бүрийн үндэстний бүлгүүдийн хэрэгцээ, эрх ашгийг хэрэгжүүлэхэд нэг санааг хүлээн авах, эс хүлээн авахтай холбоотой байдаг. Мөн түүнчлэн улс төрийн бодит амьдралд оршиж байгаа зөрчлүүдийг шийдвэрлэх арга замуудын сонголттой холбоотой байдаг. Тэгэхлээр хэний ачаар амьдрах вэ (өөрийн хэрэгцээгээ хэрхэн хангах вэ) гэдэг үндсэн асуудал гарч ирж байна. Хэрэв өөр бусад үндэстний ачаар өөрийн хэрэгцээгээ хангах эрхийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэ нь интернационализмын илрэл юм. Практикийн хувьд энэ нь онолын үндэсний ухамсарт этноцентризмын үзэл санаа оршдог ба энэ нь хоёр замаар илэрхийлэгдэж болохыг үзүүлж байна. Энэ аспектаас хандвал онолын үндэстэн угсаатны ухамсар нь үндэсний ухамсрын цөмтэй нарийн холбогддог байна.

### Дүгнэлт

Угсаатан нь ердийн (бодит) нэгтгэлийг илэрхийлдэг бол үндэстэн гэдэг бол иргэний, улс төрийн нэгтгэлийг илэрхийлдэг байна. Үндэстэн бүрэлдэн тогтох механизм нь иргэншлийн механизмыг илэрхийлдэг. Үндэсний мөн чанар нь төрөөр илэрхийлэгдэж байдаг. Үндэсний ухамсар нь үзэл суртлаар илэрхийлэгддэг бөгөөд

<sup>35</sup> Овчинникова Кристина Анатольевна "Человеческое измерение глобализирующего мира: нравственный аспект М., 2007

тэр нь нийгэм, улс төрийн нэгтгэлийн хувьд үндэсний эв нэгдлийг баталгаажуулдаг байна. Үндэсний ухамсар нь үндэсний сэтгэлзүйн хэв маягийн “дээд давхар” нь юм. Тэр нь өөртөө нийгмийн янз бүрийн үнэлэмжид бүлгийн харьцааг багтаадаг. Мөн үндэсний ухамсар нь аливаа нийгэм, улс төрийн ухамсрын хэлбэрийн хувьд нэлээд нарийн диалектик харилцан холбоотой бөгөөд харилцан нөхцөлдсөн хоёр чухал бүрэлдэхүүн хэсгийн нэгдлийг илэрхийлдэг байна. Үүнд: ердийн ба онолын ухамсар орно. Ердийн үндэсний ухамсар нь үндэсний төлөв байдалтай нарийн холбоотой байдаг ба үндэстэн угсаатны өдөр тутмын сэтгэлзүйг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, үндэсний ухамсрын эмпирик түвшин нь болдог байна. Харин онолын үндэсний ухамсар нь нэлээд өндөр түвшний ухамсрыг хэлнэ. Энэ нь бүлгийн ердийн төсөөлөл, хэрэгцээ, хүсэл зориг, эрмэлзлэлийн сонголтын үр дүн нь болдог. Үндэсний ухамсрын рациональ үзэл суртлын түвшинг илэрхийлдэг гол хүчин зүйл нь үндэсний үзэл суртал юм. Эндээс үзэхэд үндэсний ухамсар нь хүний дотоодод байдаг ч байнга илэрхийлэгддэггүй гэдэг нь харагдаж байна.

### Резюме

Национальное сознание – в целом, совокупность социональных, политических, экономических, нравственных, эстетических, философских, религиозных и других взглядов, характеризующих содержание, уровень и особенности духовного развития национально-этнической группы. Обыденное национальное сознание – также достаточно сложное по своей структуре и механизмам, многослойное и противоречивое, инерционно-консервативное и, вместе с тем, как бы “плывающее”, постоянно видоизменяющееся образование. Теоретическое национальное сознание представляет собой кристаллизованное, научно оформленное и четко социально и политически ориентированное обобщение избранных элементов массового обыденного национального сознания, осуществляемое с определенных социально-политических позиции.

### Ном зүй

1. Чугров С.В. “Глобализация и общественное сознание” М., 2008.
2. Овчинникова Кристина Анатольевна “Человеческое измерение глобализирующегося мира: нравственный аспект М.,2007
3. А.Э. Кулиджанишвили “Глобализация и национальные культуры” М.,2004
4. Торукало.В.П, “Нация: история и современность”, М.,1996.
5. Коротеева.В.В, “Теории национализма в зарубежных науках” М.,1999.
6. Поздняков Э.А.Нация. Национализм.Национальные интересы.М.,1994